



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/286

Улаанбаатар хот

ШУТИС-ийн багш, судлаачдын Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулах “2IP-2024” арга хэмжээ зохион байгуулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.1.17, 4.9.16, 4.9.21, Технологи дамжуулах журмын 18.2, ШУТИС-д төсөл, гэрээт ажил хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг санхүүжүүлэх журмын 7.3, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагааны 2024-2025 оны хичээлийн жилийн төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Шинжлэх ухааны ажилтны өдөр, ШУТИС-ийн 65 жилийн ойг тохиолдуулан ШУТИС-ийн багш, судлаачдын Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулах “2IP-2024” арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Шалгаруулалтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шилдэг бүтээл сонгон шалгаруулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар, арга хэмжээний төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээний зардлыг батлагдсан төсвийн дагуу гаргахыг Эрдэм шинжилгээ, технологи эрхэлсэн проректор (Д.Цолмонбаатар), Санхүү, хөрөнгө оруулалтын албаны ахлах нягтлан бодогч (Б.Мөнхцэнгэл), бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн захирал, ахлах нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

РЕКТОР  Т.НАМНАН

367040531



ШУТИС-ийн ректорын 2024 оны 09 дүгээр сарын 26-ний өдрийн 26 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ШУТИС-ийн багш, судлаачдын
Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулах “2IP-2024”
арга хэмжээний удирдамж
2IP-Idea, Intellectual property – Paper – Prototype

ҮНДЭСЛЭЛ:

ШУТИС-ийн багш, судлаачдын олон улсад хэвлэн нийтлүүлсэн бүтээл, зохион бүтээсэн технологи, шинэ санаа, оюуны өмчийг үнэлж олон нийтэд таниулах, урамшуулахад оршино.

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙН ТӨРӨЛ:

1. Олон улсад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл: (Paper)

Олон улсын Scopus мэдээллийн санд бүртгэлтэй, ШУТИС-ийн нэр дээр судалгааны ажлын үр дүнгээ хэвлүүлсэн тус их сургуулийн багш, харьяа хүрээлэнгийн үндсэн багш, судлаачдын бүтээлийг дараах 2 төрлөөр шалгаруулна.

1.1 Хамгийн олон бүтээл хэвлүүлсэн зохиогч:

- Нэгдүгээр зохиогч (First author)
- Холбоо барих зохиогч (Corresponding author)
- Хамтран зохиогч (Co- author)

1.2 Хамгийн их эшлэгдсэн бүтээл:

- Нэгдүгээр зохиогч (First author)
- Холбоо барих зохиогч (Corresponding author)
- Хамтран зохиогч (Co- author)

1.3 Шилдэг ахисан түвшний оюутны судалгааны бүтээл (Магистр, Доктор)

2. Шилдэг санаа (Idea) – Зохион бүтээлт:

Инженер-практикийн ач холбогдолтой цаашид патент (шинэ бүтээл, ашигтай загвар)-аар хамгаалагдах боломжтой, инженер - технологийн шинэ шийдэл бүхий санаа, түүнийг анхны загвар бүтээгдэхүүн (prototype) болгон хөгжүүлсэн бүтээл байна.

3. Шилдэг оюуны өмч (Intellectual Property):

Оюуны өмчийн патент (аж үйлдвэр)-ын эрхээр баталгаажуулсан, үйлдвэрлэл хэрэглээнд нэвтрэх бүрэн боломжтой шинэ технологи бүхий бүтээл байна.

ШАЛГАРУУЛАЛТ:

Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээлийн шалгаруулалтыг ШУТИС-ийн захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг уралдаанд ирүүлсэн материалд үндэслэн шалгаруулна. Шаардлагатай тохиолдолд шалгаруулалтад оролцогчоос нэмэлт тодруулга авч болно.

ХУГАЦАА:

Уралдаанд нэр дэвшүүлсэн бүтээлийг 2024 оны 11 дүгээр сарын 5-ны дотор research@must.edu.mn цахим хаягаар хүлээн авах ба шалгаруулалтыг 2024 оны 11 дүгээр сарын 15-оос 20-ны өдрүүдэд зохион байгуулна. Бүтээл тус бүр зөвхөн нэг ангилалд өрсөлдөнө.


- Шалгарсан бүтээлүүдийн шагнал гардуулах үйл ажиллагааг “Шинжлэх ухааны ажилтын өдөр” (11 сарын 27) зохион байгуулна.



ШУТИС-ийн ректорын 2024 оны 09 дүгээр сарын 26-ний өдрийн 88 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

| Тавигдах шаардлага | Бүрдүүлэх материал | Шагнал урамшуулал, ₮ |
|--|--|---|
| <p>1. Олон улсад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл: (Paper)</p> <p>1.1 Хамгийн олон бүтээл (journal article, review paper):</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын мэдээллийн сан SCOPUS-д бүртгэлтэй сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн байх; - Гадаад, дотоодын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд гарсан судалгааны бүтээлийг харгалзах; - "2IP-2023" шалгаруулалтад оролцоогүй бүтээл байх; <p>1.2 Хамгийн их эшлэгдсэн бүтээл (journal article, review paper, book review, book chapter, note, letter буюу short communication, book review гэх мэт):</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын мэдээллийн сан SCOPUS-д бүртгэлтэй сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн байх; - Гадаад, дотоодын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд гарсан судалгааны бүтээлийг харгалзах; - "2IP-2023" шалгаруулалтад оролцоогүй бүтээл байх; <p>1.3 Шилдэг ахисан түвшний оюутны судалгааны бүтээл (Магистр, Доктор)</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын мэдээллийн сан SCOPUS-д бүртгэлтэй сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн бүтээл байх; - "2IP-2023" шалгаруулалтад оролцоогүй бүтээл байх; | <p>Шалгаруулалтад оролцогчийн мэдээлэл (анкет маягтын дагуу)</p> <p>Шалгаруулалтад оролцогчийн мэдээлэл (анкет маягтын дагуу)</p> <p>Шалгаруулалтад оролцогчийн мэдээлэл (анкет маягтын дагуу)</p> | <p>1.1 Хамгийн олон бүтээл хэвлүүлсэн багш, судлаач:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нэгдүгээр зохиогч -1 (3 сая төг) 2. Холбоо барих зохиогч-1 (3 сая төг) 3. Хамтран зохиогч- 1 (2 сая төг) <p>1.2 Хамгийн их эшлэгдсэн бүтээл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нэгдүгээр зохиогч-1 (2 сая төг) 2. Холбоо барих зохиогч-1 (2 сая төг) 3. Хамтран зохиогч- 1 (1 сая төг) <p>1.3 Шилдэг ахисан түвшний оюутны судалгааны бүтээл (Магистр, Доктор)</p> <ol style="list-style-type: none"> 1. Нэгдүгээр байр – 0.5 сая төгрөг |
| <p>Тайлбар: Оролцогч нь үндсэн орон тооны багш, судлаач, судалгааны төв, хүрээлэнгийн судлаач, магистр, докторын оюутан байх бөгөөд бүтээл тус бүр зөвхөн нэг ангилалд оролцоно. Хамрах хугацаа: (2023.01.01-2023.12.31)</p> | | |
| <p>2. Шилдэг санаа – Зохион бүтээлт: (Idea)</p> | | |
| <p>- Инженер, технологийн шинэ шийдэл агуулсан туршилтын буюу анхны загвар (Prototype) хийгдсэн бүтээл байх; -Аж үйлдвэрийн өмчийн (патент) эрхээр хамгаалагдах боломжтой байх; -Дэвшүүлж буй санаа нь давтагдаагүй буюу тухайн зохиогчийн эсвэл хамтран зохиогчдын шинэ санаа байх;</p> <p>3. Шилдэг оюуны өмч (Intellectual Property)</p> | <p>- Шалгаруулалтад оролцогчийн мэдээлэл (анкет маягтын дагуу) - Бүтээлийн фото зураг хавсаргах. - Бүтээлийг тайлбарласан 1 минутын видео ирүүлэх</p> | <p>-Нэгдүгээр байр – 2 сая төгрөг - Хоёрдугаар байр – 1 сая төгрөг</p> |



ШУТИС-ийн ректорын 2024 оны 09 дүгээр сарын
26-ний өдрийн тушаалын нэгдүгээр хэсгээр

| | | |
|---|--|---|
| <p>-Оюуны өмчийн эрх /шинэ бүтээлийн патент, ашигтай загварын патент, бүтээгдэхүүний загвар/ - ээр баталгаажсан байх, мэдүүлэг хамаарна; -Үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх боломжтой байна. - Туршилтын загвар (Prototype) хийгдсэн бол давуу тал болох;</p> | <p>- Шалгаруулалтад оролцогчийн мэдээлэл (анкет маягтын дагуу) - Патентын гэрчилгээний хуулбар - Бүтээлийн талаар фото зураг хавсаргах. - Бүтээлийг тайлбарласан 1 минутын видео ирүүлэх</p> | <p>- Нэгдүгээр байр – 3 сая төгрөг - Хоёрдугаар байр – 2 сая төгрөг</p> |
|---|--|---|



26-ний өдрийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 2024 оны 09 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ШУТИС-ИЙН БАГШ, СУДЛААЧДЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ “2IP-2024” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ АНКЕТ (PAPER)

Овог нэр, албан тушаал _____

Салбар, тэнхим _____

Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн _____

Судалгааны чиглэл _____

Е-мэйл хаяг/Утас _____

| Олон улсад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл | | | | |
|---|----------------|---------------|----------------------|----------------|
| Шалгаруулалтад оролцох ангилал | | | | |
| (тохирох чиглэлээ () тэмдэглэнэ үү): | | | | |
| <input type="radio"/> Хамгийн олон бүтээл (journal article, review paper) | | | | |
| <input type="radio"/> Хамгийн их эшлэгдсэн бүтээл | | | | |
| № | Зохиогчийн нэр | Өгүүллийн нэр | Өгүүллийн doi дугаар | Сэтгүүлийн нэр |
| | | | | |
| | | | | |
| | | | | |



ШУТИС-ийн ректорын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 26 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ШУТИС-ИЙН БАГШ, СУДЛААЧДЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ “2IP-2024” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ АНКЕТ (ЗОХИОН БҮТЭЭЛТ, ОЮУНЫ ӨМЧ)

Овог нэр, албан тушаал _____

Салбар, тэнхим _____

Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн _____

Судалгааны чиглэл _____

E-мэйл хаяг/Утас _____


Шилдэг санаа (Idea) - зохион бүтээлт, Шилдэг оюуны өмч

Шалгаруулалтад оролцох ангилал

(Оролцох чиглэлээ () тэмдэглэнэ үү):

Шилдэг санаа (зохион бүтээлт) Шилдэг оюуны өмч

| № | Зохион бүтээгчийн нэр | Бүтээлийн нэр | Бүтээлийн танилцуулга, ач холбогдлын талаарх мэдээлэл (350 үгэнд багтаах) | Бүтээлийн фото зураг | Бүтээлийн видео тайлбар байршуулсан хаяг (и-мэйл эсвэл google drive г.м) | Патентын улсын бүртгэлийн дугаар (Шилдэг оюуны өмч төрөлд хамаарна) |
|---|-----------------------|---------------|---|----------------------|--|---|
| | | | | | | |



ШУТИС-ИЙН АХИСАН ТҮВШНИЙ ОЮУТНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ “2IP-2024” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ АНКЕТ (PAPER)

Овог нэр, _____

Салбар, тэнхим _____

Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн _____

Судалгааны чиглэл _____

Е-мэйл хаяг/Утас _____

| Олон улсад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл | | | | |
|--|----------------|---------------|----------------------|-----------------|
| Шалгаруулалтад оролцох ангилал | | | | |
| (тохирох чиглэлээ () тэмдэглэнэ үү): | | | | |
| № | Зохиогчийн нэр | Өгүүллийн нэр | Өгүүллийн doi дугаар | Сэтгүүллийн нэр |
| | | | | |
| | | | | |
| | | | | |